

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ДҮНГИЙН ТУХАЙ

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2022 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын баталсан 2022 оны 9 сарын 15-ны өдрийн 1/16 дугаар удирдамжийн дагуу Булган аймгийн Тэшиг сумын “Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч А.Анхбаяр 2022 оны 9 сарын 24-ний өдрөөс хуанлийн 7 хоногт багтаан хяналт шалгалтыг хийв.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

“Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн гаргасан заавар, журам, дүрмийн хэрэгжилтийн байдал,

Үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөлт, түүний гүйцэтгэлийн байдал,

Харилцах дансны болон кассын орлого, зарлагын гүйлгээг үндсэн баримтууд, бараа материал, үнэт цаасны тайлан, хөрөнгийн бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн журналууд, дансны бичилтүүдтэй тулган шалгах,

Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан тэнцэл гаргалт, хөрөнгийн тооллого, тооцоо бодолтын ,

Байгууллага хоорондын тооцоо өглөг авлага, түүний баталгаажуулалт, бүртгэл тайланд тусгасан байдал,

Ажиллагсдын цалин хөлс, шагнал урамшууллыг хууль тогтоомжийн дагуу тогтоож, бодож олгосон байдал

Албан томилолтын зардлын тооцоо төлсөн байдал,

Шатахуун, сэлбэгийн тооцоо бодолтын байдал,

“Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг бүрэн хамруулав.

ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Тэшиг сумын ИТХ-ын 2014 оны 29 дүгээр тогтоолоор “Тэшиг Ус” ОНӨААТҮГ-ыг байгуулсан байна.

“Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын зорилго нь “Хэрэглэгчдийг найдвартай Дулаан, Цэвэр усаар хангаж эрүүл ая тухай нөхцөлийг бүрдүүлэх орчин үеийн шинэ дэвшилтэд техник технологи нэвтрүүлж орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулж найдвартай тулаанаар хангагч байгууллага болоход оршино.” гэж тодорхойлсон байна

Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 60 дугаар тогтоолоор 5 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна

Санхүүгийн үйл ажиллагааны 1 дүгээр гарын үсгийг 2021 оны 01 сарын 01-нээс 2021 оны 05 сарын 15-ний өдрийг хүртэл С.Баярсайхан 2021 оны 7 сарын 03-наас 2021 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл П.Оюунбат, 2 дугаар гарын үсгийг 2021 оны 01 сарын 01-нээс 2021 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл Э.Оюун-Эрдэнэ нар зурсан ба Төрийн банкин дахь 410034120000481648 тоот данс, ХААН банкин дахь 5270658634 тоот данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Нягтлан бодох бүртгэлийн тайланг санхүүгийн “Smart balance” программаар бүртгэж хөтөлсөн ба бараа материалын программ байхгүй, бараа материалын орлого зарлагыг тусад нь бүртгэж байна.

Эд хариуцагчаар Б.Мөнхцэцэг ажилласан байна.

ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Булган аймгийн Төрийн аудитын газраас хийсэн аудитын шалгалтаар зөрчилгүй санал дүгнэлт авсан. Аудитаар нийт 5077.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 689.9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 2990.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1397.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн байна.

ЗУРГАА. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

“Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын 2021 оны касс харилцах, цалингийн баримт, захирлын тушаал, хүнс, бараа материалын баримт 2021 оны санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын баримт, хөдөлмөрийн дотоод журам, аудитын тайлан зэрэг баримт материалуудад тулгуурлан захирал П.Оюунбат, нягтлан бодогч Э.Оюун-Эрдэнэ, нярав Б.Мөнхцэцэг нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

6.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлтийн талаар:

ТУЗ-ийн 2020 оны 02 дугаар тогтоолоор “Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтод түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 381.422,1 мянган төгрөгөөр, нийт зардлыг 374.190,0 төгрөгөөр тогтоосон байна. Тайлант онд тус үйлдвэрийн газар нь 373.448,8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн ба 2021 оны жилийн эцэст Төрийн банкин дахь 410034120000481648 тоот дансны үлдэгдэл 19.283,1 мянган төгрөг ХААН банкин дахь 5270658634 тоот дансны үлдэгдэл 1.505,9 мянган төгрөг, нийт 20.789,0 мянган төгрөг, кассын үлдэгдэл 16,8 мянган төгрөг байна.

6.2. Цалин урамшууллын талаар:

Үйлдвэрийн газрын ажилчдын цалин хөлсөнд 110.058,2 мянган төгрөгийг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 14.922,1 мянган төгрөгийг, бараа

материал худалдан авахад 162.227,8 мянган төгрөгийг, ашиглалтын зардалд 27.679,7 мянган төгрөгийг, татварт 49.128,8 мянган төгрөгийг, түлш шатахуун сэлбэг хэрэгсэлд 2.671,2 мянган төгрөгийг зарцуулсан байна. “Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын захирлын 2021 оны 12 сарын 20-ны өдрийн Б/71 тоот тушаалаар эрхэлсэн ажилдаа амжил гаргасан 5 ажилтанд үндсэн цалингийн 20-30 хувиар тооцон 930,0 мянган төгрөгийн урамшууллыг олгосон байна. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд 2021 онд цалин, урамшуулал олгоогүй, үйл ажиллагааны зардалд 100.0 мянган төгрөгийг олгосон байна.

6.3. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:

Үндсэн хөрөнгийн 2021 оны эхний үлдэгдэл 71.125,4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр төсвийн хөрөнгөөр “Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын төлөөлөн удирдах зөвлөлийн 11 сарын 10-ний өдрийн 08 дугаар тогтоолоор санхүүгийн программ ашиглах үзүүлэлт хангасан зөөврийн компьютерыг Пи Си Молл ХХК-иас 2.639,8 мянган төгрөгөөр худалдан авч, программ хангамжийн 300,0 мянган төгрөгийг данс бүртгэлээс хасаж, хуримтлагдсан элэгдэл 55.297,0 мянган төгрөг болж жилийн эцэст 18.167,2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

6.4. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /мянган төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Бэлэн бүтээгдэхүүн	37.859,6	42.673,8	77.342,6	3.190,8
2	Аж ахуйн материал	26,1	759,9	707,2	78,8
3	Эм боох материал	0,00	47,5	20,3	27,2
4	Бичиг хэргийн материал	126,9	1023,9	595,3	555,5
НИЙТ ДҮН		48.502,7	60.944,0	96.058,8	13.427,9

2021 оны эхэнд 48.502,7 мянган төгрөгийн бараа материал дээр төсвийн хөрөнгөөр 60.984,0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 95.143,1 мянган төгрөгийн бараа материал зарлагдаж, 14 нэр төрлийн 46 ширхэг 915,7 мянган төгрөгийн бараа материалыг акталж, оны эцэст 13.427,9 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

6.5. Өглөг, авлагын талаар:

Авлагын хувьд 2021 оны эхэнд бусад байгууллагаас авах авлага 3.503,2 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах 2.449,1 мянган төгрөг, татвар, НДШ-ийн 359,1 мянган төгрөгийн авлагаас, татвар, НДШ-ийн 320,7 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, байгууллагаас авах авлага 1.617,6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант оны авлагын үлдэгдлийг авч үзвэл НДШ-ийн 38,5 мянган төгрөг, байгууллагаас авах 5.120,9 мянган төгрөгийн, хувь хүмүүсээс авах 2.449,1 мянган төгрөгийн авлага байна. Үүнээс: хувь хүмүүсээс авах 2.449,1 мянган төгрөгийн авлага нь 2017 онд үүссэн тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага байна.

Өглөгийн хувьд 2021 оны эхэнд байгууллагад төлөх 80.066,0 мянган төгрөг, хувь хүмүүст төлөх 1.812,4 мянган төгрөг, татварын 35.291,0 мянган төгрөг, НДШ-ийн 35,0 мянган төгрөгийг өглөгтэй байснаас тайлант онд байгууллагад төлөх 51.444,1 мянган төгрөг, хувь хүмүүст төлөх 1.441,6 мянган төгрөг, татварт төлөх 20.010,7 мянган төгрөг, НДШ-д төлөх 35,0 мянган төгрөгийг өглөгийг барагдуулж, оны эцэст байгууллагад төлөх 28.621,9 мянган төгрөг, хувь хүмүүст төлөх 370,8 мянган төгрөг, татварт 15.280,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

6.6. Шилэн дансны талаар: Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн системд 2021 онд төсөв, гүйцэтгэл цэсэнд 49 мэдээлэл оруулахаас, 43

мэдээллийг хугацаанд нь мэдээлж 6 мэдээллийг хугацаа хоцроон, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалтын 39 мэдээллийг оруулахаас 36 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 3 мэдээллийг хугацаа хоцроон, бусад 61 мэдээлэл оруулахаас 59 мэдээллийг хугацаанд нь шивж, 2 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

6.7. Буцалтгүй тусламжийн талаар

“Тэшиг ус” ОНӨААТҮГ-ын захирлын 2021 оны 02 сарын 16-ны өдрийн Б/09 тоот тушаалаар Тэшиг ус ОНӨААТҮГ-аас өндөр насны тэтгэвэрт гарсан Маань овогтой Чинбатын бие өвдөж яаралтай шинжилгээ өгөх, эмнэлэгт хэвтэх шаардлагатай болсон тул эмчилгээний зардалд 150,0 мянган төгрөгийн, 02 сарын 23-ны өдрийн тушаалаар машинист Б.Ган-Эрдэнийн эхнэр нь хүнд өвчтэй байгаа тул 100,0 мянган төгрөгийн, 3 сарын 22-ны өдрийн Б/18 тоот тушаалаар машинист Ч.Ганцолмонгийн төрсөн дүү хүнд өвчтэй байгаа тул 100,0 мянган төгрөгийн, 03 сарын 24-ний өдрийн Б/12 тоот тушаалаар машинист Б.Ган-Эрдэнийн эхнэр нь хүнд өвчний улмаас нас барсан тул 500,0 мянган төгрөгийн 11 сарын 08-ны өдрийн Б/65 тоот тушаалаар шинээр гэр бүл болж байгаа нягтлан бодогч Э.Оюун-Эрдэнэд 100,0 мянган төгрөгийн буцалтгүй тусламжийг тус, тус олгосон байна.

ДОЛОО. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

1. Албан томилолтоор ажилласан албан хаагч нарт албан томилолтын зардлыг олгоходоо анхан шатны баримтын бүрдэл дутуу материалаар /томилолтын ирсэн, явсан хугацааг хаагаагүй/ бодож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/ заасныг;

2. Шилэн дансны shilendans.gov.mn цахим хуудсанд 2021 онд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээллэсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т /тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх зарчмыг баримтална/ заалт, 6 дугаар зүйлийн 6.1.2-т /.....сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор тогтмол мэдээлнэ./ заасан заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй;

3. Шилэн дансны shilendans.gov.mn цахим хуудсанд байгууллагын захирал, нягтлан бодогчийн нэр утасны дугаарыг өөрчлөөгүй,

НАЙМ. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 1 актаар 167,0 мянган төгрөгийн төлбөр тогтоож, илэрсэн алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар 3 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

ЕС. ДҮГНЭЛТ

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 13.6, 13.7 дахь заалтууд, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг хэрэгжүүлээгүй анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байгаа нь дотооддоо тавих хяналт сул, Шилэн дансны тухай хуулийн 4.1.3, 6.1.2, заалтуудын хэрэгжилт хангалтгүй байна гэж дүгнэлээ.

АРАВ. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

1. Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам албан бичгээр ирүүлэх.

2. Дотоод хяналт зохион байгуулах журам боловсруулан дотоод хяналтыг оновчтой төлөвлөж, дотоод хяналтын чанар үр нөлөөг дээшлүүлэн илэрсэн

зөрчлүүдийг арилгах талаар холбогдох албан тушаалтан, ажилтанд хугацаатай үүрэг чиглэл өгч, биелэлтийг тооцон, удирдлагад танилцуулан хариуцлага тооцох санал хүргүүлж, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах.

3. Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж, гүйцэтгэлийг хянан баримтжуулж, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх.

4. Санхүүгийн тайланд тусгагдсан он дамжин үүссэн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, барагдуулах арга хэмжээг авч ажиллах.

5. Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, шалгалтын мөрөөр тодорхой ажил зохион байгуулан 2022 оны 11 дүгээр сарын 15-ны дотор аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанд албан бичгээр болон sankhuu_audit_bu@yahoo.com хаягаар хариу ирүүлэх

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧ А.АНХБАЯР

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
ДАРГА САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Б.БАТТУЛГА